



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

№ 01.

Дархан уул аймаг

**Компанийн 2023 оны санхүүгийн тайлан,
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус
гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж
батлах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Тээвэр Дархан” Хувьцаат компанийн дүрмийн 7.8 дугаар зүйлийн 7.8.3 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Тээвэр Дархан” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн тайланг баталсугай.
2. Тус компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг шинээр байгуулагдах Төлөөлөн удирдах зөвлөлд, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал М.Оюунд тус тус үүрэг болгосугай.

Хурлын дарга



Ж.ОЧИРСҮХ



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

№ 02

Дархан уул аймаг

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны зардлын төсөв, дарга,
гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, “Тээвэр Дархан” Хувьцаат компанийн дүрмийн 7.8 дугаар зүйлийн 7.8.7 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Тээвэр Дархан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хэвийн үйл ажиллагаа хангах 2024 оны зардлын төсвийг 5 220 000 төгрөгөөр тогтоосугай.
2. “Тээвэр Дархан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ОЧИРСҮХ

“Тээвэр Дархан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2024 оны
04 дүгээр сарын 29-ний өдрийн 02 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ**

№	ТУЗ-ийн гишүүний нэр	1 сарын цалин /төг/¹	1 жилийн цалин
1	Ердийн гишүүн ТУЗ-н дарга	50000	600000
2	Ердийн гишүүн	45000	540000
3	Ердийн гишүүн	45000	540000
4	Ердийн гишүүн	45000	540000
5	Ердийн гишүүн	45000	540000
6	Ердийн гишүүн	45000	540000
7	Хараат бус гишүүн	45000	540000
8	Хараат бус гишүүн	45000	540000
9	Хараат бус гишүүн	45000	540000
10	Нарийн бичгийн дарга	25000	300000
	Нийт	435000	5220000



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

№ 03.

Дархан уул аймаг

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4, “Тээвэр Дархан” Хувьцаат компанийн дүрмийн 7.8 дугаар зүйлийн 7.8.1 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 04 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Тээвэр Дархан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр: 9
 - 1.1.1. М.Жавхлан
 - 1.1.2. М.Оюун
 - 1.1.3. Ж.Мөнхтөр
 - 1.1.4. Л.Амарсанаа
 - 1.1.5. Б.Саруул
 - 1.1.6. Ж.Очирсүх
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.2.1. Д.Бумцэрэн
 - 1.2.2. Д.Чулуун
 - 1.2.3. Х.Жаргалсайхан
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2024 оны 06 дугаар сард багтаан хуралдуулж ТУЗ-ийн дарга, түүний дэргэдэх хороодыг байгуулах ажлыг шинээр сонгогдсон гишүүдийн оролцоотойгоор зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.
3. ТУЗ-ын анхны хурлаа зохион байгуулж, ТУЗ-ын дарга сонгох, компанийн засаглалын журам, баримт бичгүүдийг хэлэлцэх, цаашид хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаархи мэдээллийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Э.Жавхлантөгс)-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай” “Тээвэр Дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04-р сарын 20-ны өдрийн 04 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ОЧИРСҮХ



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

№ 04

Дархан уул аймаг

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай.

“Тээвэр дархан”ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 2 сарын 16-ны өдрийн тогтоол, хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4-р сарын 29-ний өдрийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Ээлжит хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2024 оны 2 сарын 16-ны “Ногдол ашиг хуваарилах эс тухай” №01 тоот тогтоолыг дэмжиж “**зөвшөөрсөн**” гэж дүгнэсүгэй.

Хурлын дарга



/ Ж.Очирсүх /